



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Ч.Цэрэннадмид

Утас: 95112689 Цахим хаяг: [tseb.audit@gmail.com](mailto:tseb.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	13
4. Аудитын тайлан .....	14
4.1. Ерөнхий зүйл .....	14
4.2. Материаллаг байдал .....	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	17
5.1 Залруулга .....	17
5.2 Төлбөрийн акт .....	17
5.3 Албан шаардлага .....	17
5.4. Зөвлөмж .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>19</b>



“ТУУЛЫН ХИШИГ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Л.ГАНТУЛГА ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023-03-15 № СЭА-2023/06-НА-СТА-ОНА

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан нүүрсний худалдан авалтыг харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, цалингийн урьдчилгааг суутгаагүй, авлага үүсгэлгүй шууд зардалд тайлагнасан зэрэг зөрчил илэрсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

СЭА-2023/06-НА-СТА-ОНА

## **Асуудлыг онцолсон хэсэг**

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь 2022 онд 252,655.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 268,772.5 мянган төгрөгийн зардал гарган, 16,116.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд төсөвт байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс 249,432.1 мянган төгрөгийн, айл өрхөөс 2,953.7 мянган төгрөгийн, бусад 270.0 мянган төгрөгийн зэрэг нийт 252,655.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 28,851.2 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар тасалсан байна.

Орлого дутуу төвлөрснөөс шалтгаалан төлөвлөсөн зардлыг 11,069.7 мянган төгрөг буюу 4.0 хувиар хэмнэсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

*Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	01 сарын 31	12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,139,526.33	1,732,805.07
1.1.2	Татвар НДШ-ийн авлага		
1.1.3	Дансны авлага	77,280,854.03	74,779,627.88
1.1.4	Бусад авлага	1,319,202.89	6,266,330.30
1.1.5	Бараа материал	10,972,878.29	15,107,099.99
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>116,712,461.54</b>	<b>97,885,863.24</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	354,330,435.24	501,228,281.76
1.2.2	Биет бус хөрөнгө	1,484,696,000.00	1,484,696,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,839,026,435.24</b>	<b>1,985,924,281.76</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,955,738,896.78</b>	<b>2,083,810,145.00</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	38,282,639.57	31,783,784.02
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	39,249,129.14	29,935,944.47
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	8,595,838.03	8,595,838.03
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>86,127,606.74</b>	<b>70,315,566.52</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>86,127,606.74</b>	<b>70,315,566.52</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	1,958,488,000.00	1,958,488,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604,304.98	164,604,304.98
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		160,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(253,481,014.94)	(269,597,726.50)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,869,611,290.04</b>	<b>2,013,494,578.48</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,955,738,896.78</b>	<b>2,083,810,145.00</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>387,250,886.80</b>	<b>252,655,830.76</b>
2	Борлуулалтын өртөг	229,573,895.03	232,559,664.24
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>157,676,991.77</b>	<b>20,096,166.52</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	51,307,526.06	36,212,878.08
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>106,369,465.71</b>	<b>(16,116,711.56)</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>106,369,465.71</b>	<b>(16,116,711.56)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>106,369,465.71</b>	<b>(16,116,711.56)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		-
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,958,488,000.0	164,604,304.9	160,000,000.00	(359,850,480.6)	1,923,241,824.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	1,958,488,000.0	164,604,304.9	160,000,000.0	(359,850,480.6)	1,923,241,824.3
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				106,369,465.7	106,369,465.7
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,958,488,000.0	164,604,304.9	160,000,000.0	(253,481,014.9)	2,029,611,290.0
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	1,958,488,000.0	164,604,304.9	160,000,000.0	(253,481,014.9)	2,029,611,290.0
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(16,116,711.5)	(16,116,711.5)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	1,958,488,000.0	164,604,304.9	160,000,000.0	(269,597,726.5)	2,013,494,578.4

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+) Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	<b>417,681,628.80</b>	<b>268,184,287.12</b>
1.2	Мөнгөн зарлагын дүн (-) Ажиллагчдад төлсөн Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн Бараа материал худалдан авахад төлсөн Ашиглалтын зардалд төлсөн Татварын байгууллагад төлсөн Бусад мөнгөн зарлага	417,681,628.80 393,627,025.48 62,756,675.65 36,007,108.97 202,154,177.34 36,213,172.69 41,965,399.83 14,530,491.00	268,184,287.12 <b>290,889,108.38</b> 59,819,059.06 21,557,221.29 123,291,396.80 33,197,633.16 23,817,217.21 29,206,580.86
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>24,054,603.32</b>	<b>(22,704,821.26)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+) Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-) Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(2,701,900.00) (2,701,900.00)
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(2,701,900.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+) Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-) Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>24,054,603.32</b>	<b>(25,406,721.26)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,084,923.01</b>	<b>27,139,526.33</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>27,139,526.33</b>	<b>1,732,805.07</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Хүснэгт 1. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>387,250.9</b>	<b>281,507.0</b>	<b>252,655.8</b>	<b>28,851.2</b>	<b>89.7</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	387,250.9	281,507.0	252,655.8		
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>280,881.2</b>	<b>279,842.2</b>	<b>268,772.5</b>	<b>(11,069.7)</b>	<b>96.1</b>
	Үүнээс:	м/төг					
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		229,573.9		232,559.7		
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	51,307.4		36,212.8		
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
<b>4</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	м/төг	<b>(106,369.7)</b>	<b>1,664.8</b>	<b>(16,116.7)</b>	<b>(14,451.9)</b>	

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь “Орчин үеийн техник технологи нэвтрүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулж хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний улсын стандарт хангасан цэвэр ус олборлон түгээх, хэрэглээний улмаас гарсан бохир усыг татан зайлуулах ажлыг байнгын хэвийн найдвартай хангаж, эдийн засгийн алдагдлыг бууруулах замаар салбартаа тэргүүлэгч байгууллага болно” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төв дэх төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарим засвар үйлчилгээг харилцан гүйцэтгэх, хяналт тавих,
- Сумын төв, хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан цэвэр усаар хангах иргэн, байгууллагатай гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоо хийх,
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг мөн тогтоосон үнэ тарифаар үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2009 оны 51 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,139.5	1,732.8	(25,406.7)
Авлага	77,280.8	74,779.6	(2,501.2)
Ажилчдаас авах авлага	1,319.2	6,266.3	4,947.1
Бараа материал	10,972.9	15,107.1	4,134.2
Үндсэн хөрөнгө	354,330.4	501,228.3	146,897.9
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1,484,696.0	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,955,738.8</b>	<b>2,083,810.1</b>	<b>128,071.3</b>
Өр төлбөр	86,127.5	70,315.5	(15,812.0)
Эздийн өмч	1,958,488.0	1,958,488.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604.3	164,604.3	-
Эздийн өмчийн бусад хэсэг		160,000.0	160,000.0
Хуримтлагдсан ашиг	(253,481.0)	(269,597.7)	(16,116.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,955,738.8</b>	<b>2,083,810.1</b>	<b>128,071.3</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,732.8 мянган төгрөг болж 25,406.7 мянган төгрөгөөр буурсан нь 268,184.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 293,591.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 74,779.6 мянган төгрөг болж 2,501.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагын оны эхний үлдэгдлийг барагдуулснаас голлон шалтгаалсан байна. Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 5,961.8 мянган төгрөг нь айл өрхөөс авах дулааны төлбөр, 27,268.1 мянган төгрөг нь эзэн холбогдогч тодорхой бус дансны авлага, 41,549.7 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудаас авах дулааны авлага байна.

Бусад авлага 6,266.3 мянган төгрөг болж 4,947.1 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдаас авах авлага өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,107.1 мянган төгрөг болж 4,134.2 төгрөгөөр нэмэгдсэн нь 112,083.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 107,948.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 162,701.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр 2,701.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 160,000.0 мянган төгрөгийн уурын зуухны тогоог үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 70,315.5 мянган төгрөг болж 15,812.0 мянган төгрөгөөр буурсан нь Жаргалант Алтай трейд ХХК-д өгөх 13,800.0 мянган төгрөгийн, татварын 2,012.0 мянган төгрөгийн өр төлбөрүүдийг барагдуулснаас голлон шалтгаалжээ.

Хуримтлагдсан алдагдал 269,597.7 мянган төгрөг болж 16,116.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн алдагдал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, сумын ИТХ болон Засаг даргаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж тайлант оны нийт орлогыг 281,507.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 279,842.2 мянган төгрөгөөр, ашгийг 1,664.8 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 252,655.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 268,772.5 мянган төгрөгийн зардал гарган, 16,116.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд:

- Аж ахуйн нэгж байгууллагаас халаалт, усны орлого 249,432.1 мянган төгрөг,

- Айл өрхөөс халаалт, усны орлого 2,953.7 мянган төгрөг,
- Бусад орлого 270.0 мянган төгрөг,

Нийт орлогын гүйцэтгэл 252,655.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 28,851.2 мянган төгрөг буюу 10.2 хувиар тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 268,772.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 11,069.7 мянган төгрөг буюу 4.0 хувиар хэмнэгдсэн нь төлөвлөсөн орлого дутуу төвлөрснөөс голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын “Туулын хишиг” ОНӨААТҮГ /цаашид “Туулын хишиг” ОНӨААТҮГ гэх/-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ Аудит” ХХК-ийн аудитор Ч.Цэрэннадмид, Т.Эрдэнэтуяа аудиторовын туслах Г.Уранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 269,060.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,690.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 18 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас 46,057.0 мянган төгрөгийн 60 мэдээллийг хугацаа хоцроож, 33 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/634 дүгээр албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэн алдагдалгүй ашигтай ажиллах бүхий л бололцоог ханган ажиллах, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд бүрэн мэдээлж байх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Авлагыг 2,501.2 мянган төгрөгөөр, өглөгийг 15,812.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

#### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“ЦЭСБ аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 222 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 91,217.3 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгснөөс 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 60.0 хувьтай байна.

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	4	91,217.3	2	28,214.8	50.0
Зөвлөмж	1		1		100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>91,217.3</b>	<b>3</b>	<b>28,214.8</b>	<b>60.0</b>

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Залруулга

Аудитаар нийт 189,959.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.  
Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайланд 160,000.0 мянган төгрөгөөр Засгийн газрын санг нэмэгдүүлсэн.
- Үндсэн хөрөнгийн тодруулгад 1,799.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлагнаагүй орхигдуулсан,
- НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогыг 28,159.9 мянган төгрөгөөр давхардуулсан,

Аудитаар нийт 130,752.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,170.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 83,619.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 45,963.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

### 5.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан дарга Л.Гантулгын 300.0 мянган төгрөг, нягтлан бодогч Л.Баасансүрэнгийн 600.0 мянган төгрөг, нярав С.Түмэнхандын 270.0 мянган төгрөг, нийт 1,170.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй, авлага үүсгэлгүй шууд зардалд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.3 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан 78,832.6 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “*Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно*”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 1 дэх “*Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 70,0 сая төгрөг*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “*Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн*

актыг хугацаанд нь биелүүлээгүй..... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу шаардах хуудасгүйгээр 1 дүгээр сард 32 тн нүүрс буюу 2,665.4 мянган төгрөг, 2 дугаар сард 28 тн буюу 2,121.5 мянган төгрөг, нийт 4,786.9 мянган төгрөгийн нүүрсийг зарлагадаж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **5.4.Зөвлөмж**

##### **1.Авлагын насжилт, барагдуулалттай холбоотой асуудал**

1.1.Илрүүлэлт: Олон жил дамнасан, эзэн холбогдогч нь тодорхой бус 27,268.1 мянган төгрөгийн авлагын тооцоог хянаагүй, барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах"....., Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Олон жил болсон насжилт өндөртэй авлагын тооцоог хянах, дүн шинжилгээ хийх, барагдуулах арга хэмжээ авах, найдваргүй тохиолдолд холбогдох байгууллагуудад хандаж, данс бүртгэлээс хасах.

##### **2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримт**

2.1. Тайлант онд 18,695.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт, төлбөрийг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь

бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмчийн өөрчлөлтийн тайлан, Засгийн газрын санг нэмэгдүүлсэн.	1	160,000.0			1	160,000.0	1	160,000.0				
Үндсэн хөрөнгийн тодруулгад тайлагнаагүй	1	1,799.9			1	1,799.9	1	1,799.9				
НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогыг 28,159.9 мянган төгрөгөөр давхардуулсныг залруулав.	1	28,159.9			1	28,159.9	1	28,159.9				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>189,959.8</b>			<b>3</b>	<b>189,959.8</b>	<b>3</b>	<b>189,959.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьдчилгаа цалин дутуу суутгасан.	1	1,170.0	1	1,170.0								
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага биелүүлээгүй	1	78,832.6			1	78,832.6						
Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1	4,786.9			1	4,786.9						

**“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудит**

Олон жилийн насжилттай авлагыг хянаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй	1	27,268.1					1	27,268.1				
Цахим баримтаар баталгаажгаагүй худалдан авалт хийсэн	1	18,695.1					1	18,695.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>130,752.7</b>	<b>1</b>	<b>1,170.0</b>	<b>2</b>	<b>83,619.5</b>	<b>2</b>	<b>45,963.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
мэдээлэл хугацаа хоцроосон	60				60			
мэдээллийг огт мэдээлээгүй	33				33			
<b>Дүн</b>	<b>93</b>				<b>93</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>93</b>				<b>93</b>			